



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 551

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлага худалдааны талаар авах арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дугаар тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй нийт 66,468,400.00 (жаран зургаан сая дөрвөн зуун жаран найман мянга дөрвөн зуун) төгрөгийн 3 ширхэг тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, харьяа байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2020 оны 11 дүгээр сарын 03-ны  
өдрийн 55/ дугаар тогтоолын хавсралт

**Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн  
хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар  
худалдах тээврийн хэрэгсэл**

| № | Автомашины марк,<br>улсын дугаар,<br>зориулалт, хөдөлгүүр,<br>арлын дугаар                                    | Үйлдвэрлэсэн<br>ашиглалтад<br>орсон он | Нийт<br>гүйлт<br>/км/ | Балансын,<br>Хуримтлагдсан<br>элэгдэл /төгрөг/                                                 | Худалдах<br>доод үнэ<br>/төгрөг/         | Эзэмшигч<br>байгууллага                                  |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------|-----------------------|------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------|----------------------------------------------------------|
| 1 | УАЗ-3307 маркийн,<br>бохирын тэрэг, 68-47<br>СҮЭ улсын дугаартай,<br>арлын дугаар-<br>33070070004784          | 2007/2007                              | 4064                  | 35,000,000.00                                                                                  | 2,000,000.00                             | Сүхбаатар<br>аймаг дахь<br>Бичигтийн<br>Гаалийн<br>газар |
| 2 | Тоёото маркийн,<br>микроавтобус 91-63<br>ДОА хөдөлгүүр- v2000,                                                | 1998/2007                              | 217077                | 7,818,900.00                                                                                   | 500,000.00                               | Дорнод аймаг<br>дахь Гаалийн<br>газар                    |
| 3 | Ньюндай маркийн,<br>Соната-6 суудлын, 00-<br>14 ОРА улсын<br>дугаартай, арлын<br>дугаар-<br>КМНЕТ41СР7А370995 | 2007/2014                              | 179862                | 23,649,500.00                                                                                  | 1,500,000.00                             | Орхон аймаг<br>дахь Гаалийн<br>газар                     |
|   |                                                                                                               |                                        |                       | <b>66,468,400.00</b>                                                                           | <b>4,000,000.00</b>                      |                                                          |
|   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН<br/>ДҮН</b>                                                                                 |                                        |                       | <b>66,468,400.00 (жаран<br/>зургаан сая дөрвөн<br/>зуун жаран найман<br/>мянга дөрвөн зуу)</b> | <b>4,000,000.00<br/>(дөрвөн<br/>сая)</b> |                                                          |